


“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



БАТЛАВ.

Ш.БАЯНМӨНХ

“УБДС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



Ф.БАЯРСАЙХАН

**ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2022.03.01

№.....11/13..

19/2022

2022 оны .03.. сарын ..16...-ний өдөр

Улаанбаатар хот

“Худалдагч”-ийг төлөөлж “Амгалан Дулааны Станц” ТӨХК-ийн Зуухан Цехийн Дарга Э.Ариунболд “Худалдан авагч”-ийг төлөөлж “УБДС”ТӨХК-ийн Ерөнхий инженер Ш.Мөнхжаргал нар энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хууль, Эрчим Хүчний Тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Нэгдсэн сүлжээний дүрэм, Дулааны эрчим хүч ашиглах дүрэм, Шудрага Бус Өрсөлдөөнийг Хориглох Тухай хууль, Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрлүүд, Эрчим Хүчний Зохицуулах Хорооны зохицуулагчдын зөвлөлийн тогтоол, бусад холбогдох хууль эрхийн актуудыг үндэслэн байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр Худалдагч нь 2022 онд **795366** Гкал (Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвийн 2008 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 7/158 шийдвэрээр 1Гкал=4.1868 ГДж) дулааны эрчим хүчийг нийлүүлэх, Худалдан авагч нь авсан дулааны эрчим хүчний төлбөрийг төлөх үүргийн /хавсралт №1/, гэрээ дүгнэсэн актын загвар /хавсралт №2/, худалдагчийн банкин дахь дансууд /хавсралт №3/, горимын зөрчлийн актийн загвар /хавсралт №4/, тоолуур хэмжүүрийн ажиллагааг хянаж шалгасан протоколын загвар /хавсралт №5/, дулааны эрчим хүчийг нийлүүлсэн ба авсан актын загвар /хавсралт №6/, горим, параметр зөрчсөн тохиолдолд мөрдөх бууруулсан тариф /хавсралт №7/, дулааны эрчим хүч худалдах, худалдан авахад ашиглаж байгаа тоолуур, хэмжүүрийн жагсаалт /хавсралт №8/, сүлжээний болон нэмэлт усны химийн горим /хавсралт №9/ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.2 Уг гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болох ба 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хүчинтэй. Гэрээг үргэлжлүүлэн сунгах эсвэл шинээр байгуулах тухай хэлцэл явагдаж байх хугацаанд энэхүү гэрээг мөрдөнө.

Хоёр. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

2.1 Худалдагч нь дараах эрх эдэлнэ:

- 2.1.1 “Худалдагч”-ийн эзэмшлийн шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн байдал нь хүний амь насанд аюул учруулахаар буюу осол, гэмтэл гаргаж болзошгүй байвал “Диспетчерийн Үндэсний Төв” ТӨХХК болон Худалдан авагчид урьдчилан мэдэгдэж тоноглолд сэлгэн залгалт, таслалт хийх;
- 2.1.2 Гэрээний биелэлтэд хяналт шалгалт явуулж илэрсэн зөрчлийг арилгах зорилгоор хамтарсан акт үйлдэх, нөхөн төлбөр болон алданги тооцох, хугацаатай шаардлага өгөх, мөрдөж буй хууль дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэх, зөрчлийг арилгуулах.
- 2.1.3 “Худалдагч” нь Эрчим Хүчний Улсын байцаагчийн шийдвэрээр “Эрчим Хүчний тухай хууль”-ийн 32 дугаар зүйлд заасан үндэслэлээр урьдчилан мэдэгдсэний дагуу ДЭХ-ний хангамжийг түдгэлзүүлэх;
- 2.1.4 Худалдагчийн тоног төхөөрөмж, дулааны шугам сүлжээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ хийх, өөрчлөлт оруулах /шинэчлэх, шинэ хэрэглэгч холбох г.м/ үед “УБДС” ТӨХК-ийн мэдлийн шугамд зайлшгүй таслалт хийхээр бол 3-аас доошгүй хоногийн өмнө “Худалдан авагч”-д урьдчилан мэдэгдэж, харилцан зөвшилцсөний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах;
- 2.1.5 Дараах тохиолдолд “Худалдан авагч”-д үүссэн хохирлыг “Худалдагч” хариуцахгүй.
 - а/. Форс-мажор байгалийн гэнэтийн аюул, аянга, цасан шуурга, усны үер, газар хөдлөлт, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлүүд бий болсон
 - б/. “Эрчим Хүчний Тухай” хуулийн 32-т заасан үндэслэлээр дулаан хангамжийг түдгэлзүүлсэн үеийн
- 2.1.6 “Худалдан авагч” нь гэрээнд заасан хугацаандаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээг дүгнэж, тооцоо нийлээгүй тохиолдолд “Худалдагч” нь худалдсан эрчим хүчний төлбөрийн нэхэмжлэлийг гэрээнд заасан хугацаанд гаргаж нэхэмжлэх эрхтэй. Харин ямар нэг шалтгаанаар худалдаж байгаа дулааны эрчим хүчний тооцоо тохирохгүй, тооцоо нийлэх боломжгүй нөхцөлд “ДҮТ” ТӨХХК, Эрчим хүчний зохицуулах хороонд асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

2.2 Худалдагч нь дараах үүрэг хүлээнэ:

- 2.2.1 “Худалдагч” нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал чанарын шаардлага хангасан дулааны эрчим хүч үйлдвэрлэж “УБДС” ТӨХК-д нийлүүлэх;
- 2.2.2 “Худалдагч” нь энэхүү гэрээний үүргээ биелүүлээгүй буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эрчим хүчийг тасалдуулан хохирол учруулсан бол “Худалдан авагч”-д үүссэн шууд хохирлыг хоёр талын хамтарсан актыг үндэслэн нөхөн төлөх.
- 2.2.3 “Худалдагч”-ийн буруугаас үүссэн горимын зөрчлийн хэмжээг “ДҮТ” ТӨХХК-ийн болон худалдагч, худалдан авагчийн диспетчерийн шуурхай албаны хөтөлсөн бүртгэл графикийн биелэлтийн тухай тэмдэглэл, холбогдох

- 2.2.12 Сүлжээний болон нэмэлт усны химийн чанарын мэдээг ээлж бүртээ нэг удаа буюу өдөрт 2 удаа авах.
- 2.2.13 Худалдан авагчийн тоног төхөөрөмжид ноцтой гэмтэл саатлын улмаас худалдагчийн үйлдвэрлэх ДЭХ-ний хэмжээ өгөгдсөн графикаас буурсан тохиолдолд тухайн үргэлжилсэн хугацааны дулаан түгээлтийг тоолуураар гарсан заалтыг үндэслэн тооцно. ДЭХ-ний буурсан доголдлын хэмжээг горим ажиллагаа хэвийн байсан өмнөх 3 өдрийн тухайн цагийн дулаан түгээлтийн дунджаар тооцон тогтоож төлбөр тооцоонд тусгах ба гарсан хохирлыг хамтарсан комисс томилогдон акт үйлдэж шийдвэрлэнэ. Бууруулсан тарифыг /хавсралт №7/ параметрийг хэрхэн хэлбэлзүүлснээс нь хамааруулан хувь тэнцүүлж тогтоох ба параметр хэлбэлзсэн зөрчил бүрт мөрдөнө.

Гурав. ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 Худалдан авагч нь дараах эрх эдэлнэ:

- 3.1.1 Зуны их засварын үед шугам дүүргэх, залгахад шаардлагатай нэмэлт усны хэмжээг худалдагчийн болон хотын дулаан хангамжийн горим ажиллагаанд нөлөөлөхгүйгээр шуурхай ажиллагааны шугамаар харилцан тохиролцож шийдвэрлүүлэх;
- 3.1.2 Худалдагчийн дулааны эрчим хүчний түгээлтийг тооцох үндсэн тоолууруудын хэвийн ажиллагаа, баталгаажилтад тогтмол хяналт тавих ба тоолуурт гэмтэл учрах, засварлах тохиолдолд талууд харилцан тохиролцож эрчим хүчний балансын тооцооны аргаар худалдсан, худалдан авсан эрчим хүчний тоо хэмжээг тогтоох;
- 3.1.3 Худалдагч нь сүлжээний шууд усны температурыг “ДҮТ”ТӨХК-ийн диспетчерээс өгсөн графикаас +4 хэмээс дээш хэмжээгээр 4 цагаас илүү хугацаанд тасралтгүйгээр өндөржүүлсэн бол зөрчилд тооцон шууд усны температурыг “ДҮТ” ТӨХК-иас өгсөн температурын графикаар бодож тооцоонд авах бөгөөд захиалгаас илүү дулаан үйлдвэрлэсэн гэж үзэн түгээлтээс хасч тооцно. Үүнээс шалтгаалж буцах усны температур өндөржсөн хариуцлагыг худалдан авагч хүлээхгүй байх эрхтэй.
- 3.1.4 “Худалдан авагч”-ийн эзэмшлийн шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн байдал нь хүний амь насанд аюул учруулахаар буюу осол, гэмтэл гаргаж болзошгүй байвал “ДҮТ”ТӨХК болон Худалдагчид урьдчилан мэдэгдэж тоноглолд сэлгэн залгалт, тасралт хийх;
- 3.1.5 Дулааны эрчим хүчний тооцооны хэмжих хэрэгсэл нь ашиглалтын явцад гэмтэх, буруу ажиллагаатай нь тогтоогдвол мэргэжлийн лабораторид засвар, шалгалт, тохируулга хийлгэх бөгөөд ашиглалтанд хүлээн авах үед хамтарсан үзлэг хийж тэмдэглэл үйлдэнэ. Энэ хугацааны дулаан түгээлтийг тооцохдоо горим ажиллагааны схемд өөрчлөлт ороогүй тохиолдолд хэвийн ажиллагаатай байсан өмнөх 3 өдрийн дулаан түгээлтийн дунджаар тооцно. Хэрэв горим ажиллагааны схемд өөрчлөлт орсон тохиолдолд 2 тал харилцан тохиролцон акт тогтоож “ДҮТ”ТӨХК-иар баталгаажуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ.

3.2 Худалдан авагч нь дараах үүрэг хүлээнэ:

- 3.2.1 Худалдан авагч нь өөрийн эзэмшиж байгаа тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй найдвартай ажиллагааг хангаж, худалдагчийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд аль болох хэмнэлттэй горимоор түгээх, Эрчим Хүчний Тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Техник ашиглалтын дүрэм, зааврууд болон холбогдох бусад хууль эрхийн актыг мөрдөж ажиллах;
- 3.2.2 Энэхүү гэрээ мөрдөгдөх хугацаанд дулааны эрчим хүчний үнэд ямар нэгэн өөрчлөлт ороогүй тохиолдолд 1 ГДж дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 22 дугаар тогтоолоор батлагдсан худалдах дулааны тарифыг **6,505.00** төг/ГДж-иар мөрдөх ба тарифт өөрчлөлт орсон тохиолдолд шинээр тооцож мөрдөнө. Нэмэгдсэн өртгийн албан татварыг /НӨАТ/ 10%-иар бодож нэмэгдүүлэн гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөх;
- 3.2.3 Сар бүрийн хэрэглэсэн дулааны эрчим хүчний тоолуурын заалтыг тухайн сарын эцсийн хоногийн 24 цагаар тасалбар болгон авч дараа сарын ажлын эхний 2 өдөрт багтааж худалдагч талтай тооцоо нийлэх;
- 3.2.4 Худалдан авагч нь буцах усны температурыг +4 хэмээс дээш хэмжээгээр 4 цагаас илүү хугацаанд тасралтгүйгээр өндөржүүлэн буцаасан бол зөрчилд тооцон "ДҮТ"ТӨХХК-иас өгсөн температурын графикаар бодож дутуу түгээлтийн зөрчилд тооцно. Буцах усны температурын өндөржилтийг хэмжүүрийн бичилтийг үндэслэн тооцох бөгөөд бууруулсан тарифаар /хавсралт №4/ тооцож төлбөр тооцоонд тусгана. Худалдагчийн буруугаас шууд усны температурыг "ДҮТ"ТӨХХК-иас өгсөн температурын графикаас +4 хэмээс дээш хэмжээгээр 4 цагаас илүү хугацаанд тасралтгүйгээр өндөржүүлэн буцаасан тохиолдолд захиалгаас илүү дулаан үйлдвэрлэсэн гэж үзэн түгээлтээс хасч тооцох бөгөөд үүнээс шалтгаалж буцах усны температурыг өндөржүүлсний хариуцлагыг худалдан авагч хүлээхгүй байх эрхтэй.
- 3.2.5 Худалдан авагч нь дулааны горимын тооцоог хавар, намар, өвөл, байдлаар гаргаж ЭХЯ-нд танилцуулж, салбарын ШУТЗ-ийн хурлаар батлуулан худалдагчид өгөх. Хэрэв батлагдсан горим тооцооны схемд өөрчлөлт хийх, ачаалал шилжүүлэх тохиолдолд "ДҮТ"ТӨХХК-тай хамтран хөтөлбөр боловсруулан батлаж Нэгдсэн сүлжээний дүрмийн дагуу худалдагчид мэдэгдэх.
- 3.2.6 Дулааны шугам сүлжээнд хэрэглэсэн нэмэлт усны хэрэглээг сар бүрийн дүнгээр тооцоог дүгнэж акт үйлдэн баталгаажуулах ба хагас жилээр тооцоог нэгтгэн дүгнэж "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн зардалд тусгаснаас /УБДС ТӨХК-ийн нэмэлт усны зарцуулалтын төлөвлөгөөгөөс/ хэтэрсэн тохиолдолд 1 тонн тутамд 1380 /НӨАТ-ороогүй/ /Нэг мянга гурван зуун наян/ төгрөгийн төлбөрийг төлөх;
- 3.2.7 Нэмэлт усны зарцуулалтын хэмжүүр ажиллагаагүй болсон тохиолдолд засварын бус улиралд буюу горим ажиллагаа тогтвортой байх үеийн хэвийн ажиллагаатай байсан өмнөх 3 хоногийн дундаж зарцуулалтаар тооцоо хийнэ.
- 3.2.8 Худалдагчийн тоног төхөөрөмжийн ноцтой гэмтэл саатлын улмаас худалдан авагчид нийлүүлэх ДЭХ-ний хэмжээ өгөгдсөн графикаас буурсан /даралт, зарцуулалт, температурын хэлбэлзэл/ тохиолдолд тухайн үргэлжилсэн хугацааны дулаан түгээлтийг тоолуураар гарсан заалтыг үндэслэн тооцно.

Буурсан доголдлын хэмжээг горим ажиллагаа хэвийн байсан өмнөх 3 өдрийн тухайн цагийн дулаан түгээлтийн дунджаар тооцон тогтоох бөгөөд бууруулсан тарифаар тооцож төлбөр тооцоонд тусгана. Бууруулсан тарифыг /хавсралт №7/ параметрийг хэрхэн хэлбэлзүүлснээс нь хамааруулан тогтоох ба параметр хэлбэлзсэн зөрчил бүрт мөрдөнө.

- 3.2.9 Худалдан авагчийн хүсэлтээр Амгалан дулааны станцыг зуны сул зогсолтын тодорхой хугацаанд ажиллуулах шаардлага үүссэн тохиолдолд станц ажилласан үйл ажиллагааны шууд /ус, цахилгааны зардал болон ажлын шаардлагаар сул зогсолтод байгаа хүмүүсийг дуудаж ажиллуулсан цалингийн зардлын зөрүү/ зардлыг тооцоонд тусган, тооцооны актын дагуу нэхэмжлэл гаргаж төлбөрийн тооцоо хийнэ.
- 3.2.10 Нэмэлт ус халаасан дулааны эрчим хүчний тооцоог тоолуурын заалтыг үндэслэн сар бүрийн тооцооны актанд тусгаж тооцоо хийнэ.

Дөрөв. ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦООНЫ НӨХЦӨЛ

- 4.1 Тухайн сард нийлүүлсэн дулааны эрчим хүчний тоо, хэмжээг талууд дараа сарын 01-ний өдрийн “0” цагаар тоолуурын заалтыг үндэслэн цахимаар солилцох ба Диспетчерийн Үндэсний Төвийг /”ДҮТ”ТӨХХК/ оролцуулан харилцан тохиролцоно. Энэ нь борлуулалтын орлого тооцох үндсэн баримт болно.
- 4.2 Талуудын хоорондын төлбөр тооцоог Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийн 8.1-т заасны дагуу эрчим хүчний сүлжээ, тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг дээр тавигдсан тоолуур хэмжих хэрэгслийг ашиглан хийнэ.
- 4.3 Эрчим хүч худалдан авагч Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн сард худалдан авсан дулааны эрчим хүчний төлбөрийг тухайн сардаа бүрэн төлөөгүй тохиолдолд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.1 хүртэл хувьтай тэнцэх алдангийг хоног тутамд төлнө. Тухайн сарын төлөгдөөгүй төлбөрт алданги төлөх нийт хугацаа 30 хоногоос хэтрэхгүй байна. “Худалдагч”, “Худалдан авагч”-ийн үйл ажиллагаанаас үл хамааран дулааны эрчим хүчний үйлдвэрлэлт түгээлтийн хэмжээ өсч, буурч болох бөгөөд тухайн өөрчлөлтийг “ДҮТ” ТӨХК-д талууд бичгээр мэдэгдсэн байна. Үүнийг сар бүрийн дулаан үйлдвэрлэлт, түгээлтийн өөрчлөлтийг тооцох үндэслэл болгоно.
- 4.4 Тооцоо нийлэх актыг худалдагч, худалдан авагч талууд сарын эхний ажлын 2 хоногт багтаан дуусгах бөгөөд гэрээ дүгнэх ажлыг тэгш тоотой улиралд худалдагч тал худалдан авагчийн талд, сондгой тоотой улиралд худалдан авагч тал худалдагчийн талд дараа сарын 20-ны дотор очиж дүгнэнэ. Гэрээ дүгнэсэн протоколд урамшил, алдангийн хэмжээг тэмдэглэнэ. Гэрээ дүгнэх хугацаа хоцорсон тохиолдолд буруутай талд хоног тутамд 10,000 төгрөгийн торгууль ногдуулна.
- 4.5 Хоорондоо харилцан хамааралтай сүлжээний тоноглолын засвар үйлчилгээний графикийг харилцан тохиролцож, “ДҮТ”ТӨХХК-ийн техникийн удирдлагатай зөвшилцөж захиалгаар уялдуулан гүйцэтгэж байна.
- 4.6 Худалдагчийн хүсэлтээр нүүрсний төлбөр, төмөр замын тээврийн зардал, НДШ, хувь хүний орлогын албан татвар, ус, газрын төлбөрийг харилцан

- тохиролцсоны үндсэн дээр хоорондын тооцоогоор протокол тэмдэглэл үйлдэн хийж болно.
- 4.7 Худалдан авагч нь сарын захиалгат дулааны эрчим хүчний төлбөрийг сарын хугацаанд жигд төвлөрүүлнэ.
 - 4.8 Талууд өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмжид төлөвлөгөөт бус аваарийн байдлаар шаардлагатай засвар үйлчилгээ хийх тохиолдолд “ДҮТ”ТӨХХК-д урьдчилан захиалга өгч зөвшөөрөл авч үргэлжлэх хугацааг харилцан тохиролцож хэрэглэгчдэд таслалтын талаар мэдэгдэнэ. Дээрх тохиролцсон хугацаандаа ажлаа дуусаагүйгээс худалдагч, худалдан авагч талуудад хохирол учруулсан бол ЭБЭХ-ний Сайдын 2010 оны 127-р тушаалаар батлагдсан “Нэгдсэн Сүлжээний Дүрэм”-ийн дагуу зөрчлийг судлан бүртгэж “Эрчим Хүчний Тухай” хуулийн 36 дугаар зүйл болон ТЗЭХ-ын аж ахуйн харилцааны дүрмийн 10 дугаар зүйлд заасны дагуу хохирлыг аль буруутай тал нь нөхөн төлнө.
 - 4.9 Өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмжид гарсан гэнэтийн аваарь ослоос шалтгаалан дулааны үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээг бууруулсан, тасалдуулснаас үүссэн хохирлыг талуудын хамтарсан комисс тогтоож буруутай тал нь гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.
 - 4.10 “ДҮТ”ТӨХХК-аас зохицуулагдах дулааны ачааллын график, горим, дулааны эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөөний биелэлт, горимын актын талаар гарах маргааныг Эрчим хүчний зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлж байна.
 - 4.11 Худалдан авагч нь гэрээний хугацаанд худалдан авах дулааны эрчим хүчний төлөвлөгөөний захиалгыг жилийн 2-оос илүүгүй хувийн өөрчлөлттэй төлөвлөж жилийн эцсийн гэрээ дүгнэж хариуцлага хүлээнэ.

Тав. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨЛӨЛ

- 5.1 Байгалийн гамшиг /хүйтрэлт, аянга, гал түймэр, усны үер, газар хөдлөлт, хүчтэй салхи, мөсдөлт, дайн байлдаан гэх мэт/, хүний амь нас, эд хөрөнгөд аюул учрах нөхцөл үүссэн, үймээн самуун болсон, ажил хаялт зарласан зэрэг давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан учирсан хохирлыг гэрээнд оролцогч талууд хариуцахгүй.
- 5.2 Талууд цаг агаарын онцгой нөхцөл байдалд ажиллах журмыг баримтлан гарсан аваарийг богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээг авч ажиллах бөгөөд эрчим хүчний хангамжийг сэргээхэд шаардагдах хугацаа, залгалт хийж эхлэх хугацааг харилцан шуурхай мэдээлж ажиллана.

Зургаа. УРАМШУУЛАЛ

- 6.1 Энэхүү гэрээний ач холбогдлыг өндөржүүлэх, өр авлагыг нэмэгдүүлээгүй, гэрээний заалтуудыг бүрэн хэрэгжүүлэхэд идэвх зүтгэл гарган ажилласан ажилтнуудыг жилийн эцэст гэрээ дүгнэх явцад талуудын санаачилгаар гэрээ дүгнэсэн акт, хамтын гэрээний заалтыг үндэслэн урамшуулал олгож болно.

Долоо. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Гэрээний биелэлттэй холбогдож үүссэн маргаантай асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд эс хүрвэл Эрчим Хүчний Зохицуулах Хороонд тавьж шийдвэрлүүлнэ. Уг асуудал нь Эрчим Хүчний Зохицуулах Хорооны хүрээнд шийдэгдэхгүй бол гомдолтой тал нь шүүхэд хандаж болно.

Найм. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Энэхүү гэрээ болон нэмэлт өөрчлөлтийг нь Монгол хэлээр 3 хувь үйлдэж "Худалдагч", "Худалдан авагч" талуудын Гүйцэтгэх Захирлууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс хүчин төгөлдөр болно. Уг гэрээг талууд тус бүр хадгалах бөгөөд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна. Гэрээг "ДҮТ" ТӨХХК-д бүртгүүлсэн байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА:

..... Э.АРИУНБОЛД

ЗӨВШӨӨРСӨН:

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖЛЫГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

..... О.УДВАЛ

ИНЖЕНЕРИЙН ХЭСГИЙН АХЛАХ
ИНЖЕНЕР

..... Б.БАТЦООЖ

ГОРИМЫН ХЯНАЛТ, ТООЦООНЫ
ИНЖЕНЕР:..... С.НАРАНТУЯА

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН:

..... Г.САРУУЛ

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:

..... Ш.МӨНХЖАРГАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯ-БО:

..... Л.БАЯРСАЙХАН

ШУУРХАЙ УДИРДЛАГА, ГОРИМ
ТОХИРУУЛГЫН АЛБАНЫ ДАРГА:

..... М.УУГАНБАЯР

ГОРИМ ТОХИРУУЛГЫН АЛБАНЫ ДАРГА
Т.АЛТАНГЭРЭЛ

ХЯНАСАН:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН:

..... Т.ЭНХТӨР

2022 ОНД УБДС ТӨХК-ИЙН АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИАС ХУДАЛДАН
АВАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАХИАЛГА, ТҮҮНД ТӨЛӨХ САР БҮРИЙН
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

2022 он сар, улирлаар	Худалдаж авах дулааны хэмжээ /Гкал/	Дулааны үнийн тариф / төг/	Тарифаар тооцсон дулааны төлбөрийн хэмжээ /мян.төг/	НӨАТ-тай төлбөрийн хэмжээ /мян.төг/	Нийт дүн /мян.төг/
1-р сар	168,146.00	27,653.81	4,649,877.54	464,987.75	5,114,865.29
2-р сар	118,183.00	27,653.81	3,268,210.23	326,821.02	3,595,031.25
3-р сар	94,443.00	27,653.81	2,611,708.78	261,170.88	2,872,879.66
1-р улирал	380,772.00		10,529,796.54	1,052,979.65	11,582,776.20
4-р сар	43,988.00	27,653.81	1,216,435.79	121,643.58	1,338,079.37
2-р улирал	43,988.00		1,216,435.79	121,643.58	1,338,079.37
9-р сар	15,914.00	27,653.81	440,082.73	44,008.27	484,091.01
3-р улирал	15,914.00		440,082.73	44,008.27	484,091.01
10-р сар	61,092.00	27,653.81	1,689,426.56	168,942.66	1,858,369.22
11-р сар	108,569.00	27,653.81	3,002,346.50	300,234.65	3,302,581.15
12-р сар	185,031.00	27,653.81	5,116,812.12	511,681.21	5,628,493.33
4-р улирал	354,692.00		9,808,585.18	980,858.52	10,789,443.69
Жилийн Дүн	795,366.00		21,994,900.24	2,199,490.02	24,194,390.27

Жич: ЭХЗХ-ны 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 22 дугаар тогтоолоор батлагдсан худалдах дулааны тарифыг улирал бүрээр баримтлан тооцов.

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ТООЦООНЫ ИНЖЕНЕР

С. НАРАНТУЯА

“УБДС” ТӨХК-ИЙН ТООЦООНЫ ИНЖЕНЕР

Ө.БИЛГҮҮН